

13. Одоо эсвэл хэзээ ч үгүй ... гэж Есүс Сүйт бүсгүйдээ хэлж байна.

(English Title - NOW or NEVER, My Bride! Where is your Allegiance?)

12 сарын 13, 2014 _ Эгч Кларид Есүсээс ирсэн үгс

Бүх юмс нурах үед, чи дэлгүүр хэсэж, худалдаа наймаа хийж, баяр тэмдэглэж байх үү эсвэл залбирлынхаа өрөөнд намайг аргадан, дуртайяа сууж байх үү? Чи хаана байх вэ? Хоргодох газар үү эсвэл энэ ертөнцөд алба гувчуур төлөн өндөрлөг газар байх үү?

Чиний үнэн сэтгэл хаана байх вэ? надад үү? өөртөө юу? эсвэл энэ ертөнцөд, Сатанд үү? Хаана байгаа юмс чамд хамгийн хамаатай вэ? банканд үү? Гэр бүлтэйгээ юу? Надтай юу? Чиний үнэн сэтгэл хаана байх вэ Миний Сүйт бүсгүй минь? Гэнэт үерийн ус чамайг нөмрөн авах үед чи хаана байх вэ?

Одоо тэр шийдвэрийг гаргахаар Би чамайг дуудаж байна. Би нулиσμαа дуслуулан Сүйт бүсгүйгээ дуудаж байна. Миний Хайрын хоргодох газар руу Надтай хамт орооч гэж гуйж байна. Тэнд чи Намайг шаналан байгааг харах болно, тэнд чи Миний хамгаалалтыг олох болно. Тийм ээ Би шаналж байна, хэзээ хорон санаа үгүй болтол Би шаналсаар байх болно. Тийм ээ, энэ ертөнцийн гял цал юмсын төлөө Намайг орхин, өөрийгөө худалдахаар дахин дэлгүүр рүү алхах Сүйт бүсгүйгээ харан Би асгаруулан үйлж байна.

Энэ бол энгийн л мэссэж , энд ямар ч түвэгтэй юм байхгүй. Би түүнтэй хамтрах хэрэгтэй байна, Надад түүний тайвшрал хэрэгтэй байна. Түүний дөлгөөн харц миний харцтай мэндэлж, Би түүгээр зөөлөн тэврүүлж хайрлуулмаар, түүний цэвэр ариун дуу хоолой намайг тайвшруулж өдөр бүр харж хандах ёстой юмсаас холдуулан, нойрондоо автан тайвширмаар байна.

Сүйт бүсгүй минь, энэ Ариун улиралд энэ ертөнцийн зуршлаа орхин Над руу ир, Намайг өөрийн үүрэг даалгавараа умарттал, чамайг хүйтэн зүрх гарган холдсныг марттал Миний шархыг боон Намайг асран тэнхрүүлж, нууц газар болох Миний хайрын хоргодох газар руу ирээч.

Сүйт бүсгүйн минь зэрвэсхэн харц ямар их утга учиртайг чи даанч мэдэхгүй. Хааны төрсөн өдрийн баярын цэнгүүнд оролцоор бүжгийн танхимд цугларагсдын дунд өөрийгөө байна гэж төсөөл дөө. Хаалган дээр хүн бүр гоо сайхнаараа эгнэн жагсаж, бүжгийн талбай руу цувран орохдоо хааныхаа нүдэнд өртчих гээд сээтэгнэн харна. Хүн бүр дараагийн удаад 'занга' аа барьж авна, алдар нэр, хөрөнгө чинээ, байр суурь, эрх мэдлийн төлөөх энэ тоглоом хэзээ ч төгсөхгүй.

Гэтэл гэнэт бүрээн дохио дуугархад бүгд хаалга үү эргэж, Би, Хаан орж ирээд энэ танхим дахь бүх хүний бодлыг нэг бүрчлэн уншина. Энэ бүрээн дуу нь Тэр гэдгийг мэдэж, тэд цэнгүүн ээ дуусгах болсондоо бүхмидана. Тэд яг хүсэл шунал нь бадарч байх үедээ баригдсандаа маш ихээр дургүйцнэ. **Тэр** тэнд хаан шиг хувцаслан, бүхэл дэлхий ертөнцийг эзэгнэх бүрэн эрхтэйгээр зогсоно. **Тэр** цугларагсдыг гүйлгэн харан, өрөөн доторх бүх хүмүүсийн бодол, мэдрэмжийг уншихад **Тэр** тэдэнд Танихгүй нэгэн байлаа. Харин өрөөний буланд ганцаар үлдсэн нэгэн хатагтай сууж байлаа. Тэр эмэгтэйд өөрийн гоо сайхныг гайхуулж тоглоомонд оролцох сонирхол байхгүй байлаа. Ганцхан тэр эмэгтэй л сүр жавхлант Хааны харааг булаав. Тэр эмэгтэй бусдаас хамаагүй өөр, түүний дотоод гоо сайхан нь үнэхээр гайхалтай байсан нь Хааныг гайхшруулав.

Тэр түүн рүү эелдгээр алхан очиж, түүнийг өргөн, гар дээрээ түүний гарыг тавьж , ” Миний хатан болох зохистой нэгнийг Би олчихлоо” гэж мэдэгдэв.

Цугласан олон цочирдон, тэр эмэгтэй бол ёстой хэн ч биш шүү дээ? Тэр чинь ядаж хааны ургийн хүн биш шүү дээ?, түүний навсайсан хувцсыг хараач гэж уулга алдан, алмайран, нам гүм болов.

Сүйт бүсгүйчүүд минь, Би та нарын дээгүүр гүйлгэн харахдаа юуг тань харах хэрэгтэй вэ? гэвэл чиний бодол, чиний зүрхэнд юу бодогдож байгааг харах?. Чи Надтай байхыг үл тэвчин, дэлгүүрээс авах юмныхаа урт жагсаалтыг харан, оройтох нь дээ гэж хүлээж ядан суудаг уу? эсвэл Хаан минь бидний дунд байна гэж сэтгэл хөдлөн өөрсдийгөө ялан дийлж сууна уу? Ийм Сүйт бүсгүйг Би хайж байна, тэр надад үнэхээр хайртай байдаг, түүнд дэлгүүр явах сонирхол ч байхгүй, цаг ч байхгүй, зөвхөн Надтай л байдаг. Тэр эмэгтэй найз нөхөдтэйгөө сээтэгнэн сууж хооллосноос, миний уух аяганаас уухыг илүүд үздэг. Би энд чиний дэлхийн зовлонт байдлыг харан уй гашууд автан сууж байна, ... тийм ээ Би Чиний дэлхий гэж хэлсэн, яагаад гэвэл энэ нь Миний дэлхийг дуурайсан юм юу ч алга. Би, юу та нарын дээр гэнэт ирж, энэ нь зугатан зайлах аргагүй болно гэхээс гашуудан харуусаж байна.

Би Сүйт бүсгүйгээ дэлгүүр рүү, хоолны газрууд руу, баярын цэнгүүн рүү хайн очиход, тэд бусад харчуултай сээтэгнэж, садар самуунд уруу татагдан, түүнийг хөгжөөх Сатаны урхинд орон хөөрөн баясана. Харин одоо Би та нарыг дуудхаас, хайхаас, гуйхаас залхаж байна. Би үнэхээр залхаж байна. Хэрэвээ чи буцаж ирмээр байвал, хурдан ир, одоо тийм ч их цаг үлдээгүй, одоо эсвэл хэзээ ч үгүй Сүйт бүсгүйчүүл минь. Одоо эсвэл хэзээ ч үгүй, одоо эсвэл хэзээ ч үгүй.